

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 3-р сарын 27-ны өдөр

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон “Хишиг-Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараах асуудлуудыг **ТОГТООЛ НЬ:**

НЭГДҮГЭЭР АСУУДАЛ. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХОЁРДУГААР АСУУДАЛ. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ГУРАВДУГААР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны бизнес төлөвлөгөөг танилцуулан батлах тухай;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 үйл ажиллагааны тайланг сонсож, цаашид компанийн 2020 оны үйл ажиллагаанд мөрдөх бизнес төлөвлөгөөг баталсугай.

ДӨРӨВДҮГЭЭР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай;

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дараахь гишүүдийг улируулан сонгосугай.
 - 1) Д.Итгэл
 - 2) М.Халиунбат
 - 3) Ч.Мөнхбаяр
 - 4) Я.Нэргүй
 - 5) Ц.Роза
 - 6) Б.Энххорол

- 7) Д.Гонгор
- 8) Н.Цэцэнхаан
- 9) Д.Сэржамц

ТАВДУГААР АСУУДАЛ. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг бүртгэлээс хасах эсэх тухай шийдвэрлэх тухай;

5. Компанийн нэр дээр бүртгэлтэй жагсаалт бүхий ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг бүртгэлээс хассугай.

ЗУРГААДУГААР АСУУДАЛ: Хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулах гэрээний төслийг хэлэлцэн батлах тухай;

6. Хувьцаа эзэмшигчдийн хооронд өөрсдийн эзэмшлийн хувьцааны хувьд тодорхой эрх, үүрэг харилцан тогтоосон гэрээг байгуулахаар зөвшөөрсүгэй.

Бусад: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж зохих бүртгэлийг хуульд заасан хугацаанд тус тус зохих журмын дагуу бүртгүүлэхийг Өмгөөллийн “И Эл Си” ХХН-ийн хуульч С.Батчимэг, Д.Номин-Эрдэнэ ҮРД:ТГ93040300\д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.НЭРГҮЙ